

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Менежментийн захидал	8
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	11
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ ТӨРИЙН ТҮҮХИЙН
МУЗЕЙН ЗАХИРАЛ Н.ОЮУНТЭГШ
ТАНАА

2020.02.20 № 06/532
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол төрийн түүхийн музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол төрийн түүхийн музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол төрийн түүхийн музейн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Монгол төрийн түүхийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирал Н.Оюунтэгш Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн шатахууны зарцуулалт, авлага барагдуулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол төрийн түүхийн музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол төрийн түүхийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 03-наас 2020 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Өлзийт экаунт аудит” ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол төрийн түүхийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 06 тоот дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол төрийн түүхийн музейн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төрийн түүхэнд холбогдох дурсгалыг цуглуулж, хадгалан хамгаалах судлан шинжлэх, ирээдүйн хойчдоо өвлүүлэн үлдээх, монгол төрийн түүхэн хөгжил, залгамж шинжийг сурталчлан нийгмийн ухамсарт нөлөөлж төлөвшүүлэх” гэсэн байна.

Монгол төрийн түүхийн музейн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн түүхтэй холбоотой түүх соёлын дурсгалт зүйлсийг цуглуулах, хадгалах, хамгаалах, судлан шинжлэх, дэлгэн үзүүлэх, сурталчлах үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт гарсан байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 382 тоот “Журам батлах тухай” тогтоол.
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 25 тоот “Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” тогтоол.
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 24 тоот “Төрийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоол

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Монгол төрийн түүхийн музейн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2015 онд боловсруулж мөрдсөн учир сүүлийн жилүүдийн өөрчлөлтүүдийг тусгаагүй Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Монгол төрийн түүхийн музейн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Интерактивын эмралд” программ хангамж ашигладаг байна.

Монгол төрийн түүхийн музейн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Монгол төрийн түүхийн музейн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 8 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 217,838.8 мянган төгрөгөөс тооцон 4,356.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 5,004.9 мянган төгрөгөөр тооцсон нь нийт зардлын дүнг суурь үзүүлэлтээр сонгож тайлант жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын хэмжээ өссөнтэй холбоотой.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Монгол төрийн түүхийн музейн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,900.7 мянган төгрөгөөр буюу 1,3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансанд гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	977.5	977.5	0.0
Авлага	50,507.3	6,264.7	(44,242.6)
Урьдчилж төлсөн зардал	8,215.0	8,254.9	39.9
Бараа материал	63,703.8	61,464.9	2,238.9)
Үндсэн хөрөнгө	474,181.8	512,722.7	38,540.9
Нийт хөрөнгө	597,585.4	589,684.7	7,900.7
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	597,585.4	589,684.7	7,900.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	597,585.4	589,684.7	7,900.7

Авлага дансны үлдэгдэл буурсан нь 2018 оны тайлант жилд “Төрийн 7 эрдэнэ” үзмэр хийлгэхээр “Хүннү арт” ХХК-тай гэрээ байгуулан төлбөрийг шилжүүлж авлага үүсгэсэн. 2019 оны тайлант жилд музейн үзмэр болох “Төрийн 7 эрдэнэ”-ийг хүлээн авснаар авлагын дүн буурсан байна.

Тайланд тусгагдсан 6,197.4 мянган төгрөгийн авлага нь 2007 онд музейн ашиглалтын өмнөх захиргааны сонгон шалгаруулалтаар шалгарсан “Оргилсофт” ХХК техник хэрэгслээ дутуу нийлүүлсний улмаас үүссэн.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь 104 нэр төрлийн 7,308.4 мянган төгрөгийн бараа материал акталж данс бүртгэлээс хассанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 52,154.9 мянган төгрөгөөр өссөн нь урд онд дараа тооцоогоор авлага үүсгэж бүртгэсэн түүх соёл, музейн зүйлс 43,200.0 мянган төгрөг, худалдан авсан 7,513.4 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 1,441.9 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 589,684.7 мянган төгрөг болж 7,900.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 240,905.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 233,668.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 7,236.9 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд нийт 240,905.2 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 232,802.7 мянган төгрөг буюу 96.64 хувиар төсвийг зарцуулж үлдэгдэл 8,102.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 8 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 51,116.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 43, 200.0 мянган төгрөгийн түүх соёл музейн үзмэр, 1,441,9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийт 44,641.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн тодруулга тайланг бэлтгэхдээ зөрүү үүсгэснийг залруулж, 6,524.5 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Монгол төрийн түүхийн музейд дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Монгол төрийн түүхийн музей нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 149 мэдээллээс 107 мэдээллийг хугацаанд нь, 38 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээллийг байршуулаагүй хугацаа хүлээгдэж байгаа 3 мэдээлэл байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол төрийн түүхийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Монгол төрийн түүхийн музейн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дугаар заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайланд тусгагдсан 6,197.4 мянган төгрөгийн авлага нь 2007 онд музейн ашиглалтын өмнөх захиргааны сонгон шалгаруулалтаар шалгарсан Оргилсофт ХХК техник хэрэгслээ дутуу нийлүүлсний улмаас үүссэн байна. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2016 оны 3 дугаар сарын 23 өдрийн 101/ШЗ2016/11990 тоот захирамжаар эх хувь гэрээгүй байгаа нь нотлох баримтын шаардлага хангахгүй үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзжээ. Төр засгийн үйлчилгээ эрхлэх газрын 2018 оны 01 дүгээр сарын 09 өдрийн 26 тоот бичгээр эх гэрээ архивд байхгүй болохыг мэдэгдсэн байна.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр авлага нь тухайн байгууллагад бодитой оршин байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж он удаан жил дамжсан авлагыг зохих журмын дагуу удирдах дээд байгууллагад танилцуулж шийдвэрлүүлэн, бүртгэлд тусгаж ажиллахыг зөвлөж байна.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

2007 оноос эхлэн авлагыг барагдуулахаар ажилласан ч хүндрэлтэй байгаа тул авлагыг данс бүртгэлээс хасах асуудлыг шийдэж өгөхийг хүссэн.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант оны шатахууны зарцуултанд 2018 оны 9 дүгээр сарын 14-ний өдрөөс 12 дугаар сарын 3-ны өдрийн хооронд зарцуулсан 327,0 мянган төгрөгийн шатахууны зардлыг тайлант оны зардлаар тайлагнасан байна.

2.2. Эрсдэл:

Аж ахуйн нэгж байгууллагад бүртгэгдсэн ажил, гүйлгээ буюу үйл явдал нь тухайн тайлант хугацаанд тохиолдсон батламж мэдэгдэл хангагдахгүй байх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дүгээрт “нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь” гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг хэрэглэнэ гэж заасныг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>123,403,555.87</u>	<u>76,962,008.94</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	977,502.00	977,502.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	977,502.00	977,502.00
31110	Төгрөг	977,502.00	977,502.00
33	АВЛАГА	50,507,305.87	6,264,711.94
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		67,311.94
335	Бусад авлага	50,507,305.87	6,197,400.00
3351	Байгууллагаас авах авлага	50,507,305.87	6,197,400.00
34	УРЬДЧИЛГАА	8,214,968.00	8,254,868.00
34200	Төсөвт байгууллага	8,214,968.00	8,254,868.00
35	БАРАА МАТЕРИАЛ	63,703,780.00	61,464,927.00
354	Хангамжийн материал	63,703,780.00	61,464,927.00
35410	Бичиг хэргийн материал	8,025,077.00	6,608,069.00
35420	Аж ахуйн материал	42,571,065.00	38,750,915.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,510,300.00	2,767,390.00
35440	Түлш, шатах тослох материал	796,900.00	109,575.00
35470	Бусад хангамжийн материал	10,800,438.00	13,228,978.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>474,181,783.74</u>	<u>512,722,728.18</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	474,181,783.74	512,722,728.18
392	Биет хөрөнгө	473,906,484.64	512,667,279.53
39203	Авто-тээврийн хэрэгсэл	6,500,000.00	6,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(6,500,000.00)	(6,500,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	48,141,774.75	51,065,224.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	(30,142,729.87)	(38,654,458.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	68,174,560.00	68,174,560.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(62,537,377.04)	(66,776,996.64)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	441,516,160.80	484,716,160.80
39214	Бусад үндсэн хөрөнгө	129,971,307.30	136,002,807.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	(129,971,307.30)	(130,614,114.06)
39217	Ном	8,754,096.00	8,754,096.00
393	Биет бус хөрөнгө	275,299.10	55,448.65
39301	Програм хангамж	41,776,640.00	41,776,640.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(41,501,340.90)	(41,721,191.35)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>597,585,339.61</u>	<u>589,684,737.12</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>597,585,339.61</u>	<u>589,684,737.12</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	597,585,339.61	589,684,737.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	742,060,566.40	742,060,566.40
51101	Өмч:-төрийн	742,060,566.40	742,060,566.40
512	Хуримтлагдсан үр дүн	(148,751,493.19)	(156,652,095.68)
51210	Өмнөх үеийн үр дүн	(208,099,240.46)	(148,751,493.19)
51220	Тайлант үеийн үр дүн	59,347,747.27	(7,900,602.49)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,276,266.40	4,276,266.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>597,585,339.61</u>	<u>589,684,737.12</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	277,186,594.70	242,346,750.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	586,194.70	1,441,550.00
120	Нийтлэг татварын бус орлого	586,194.70	1,441,550.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,441,550.00
120009	Бусад орлого	586,194.70	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		1,441,550.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	276,600,400.00	240,905,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	276,600,400.00	240,905,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	276,600,400.00	240,905,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	217,838,847.43	250,247,352.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	217,838,847.43	250,247,352.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	201,051,951.06	240,144,879.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	146,395,699.34	168,029,294.99
210101	Үндсэн цалин	146,395,699.34	168,029,294.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,510,153.52	20,953,036.25
210201	Тэтгэврийн даатгал	17,510,153.52	20,953,036.25
2104	Хангамж, бараа материалын зардал	6,794,410.10	16,579,124.50
210401	Бичиг хэрэг	2,490,048.50	2,168,208.00
210402	Тээвэр, шатахуун	1,423,140.00	5,855,261.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	456,451.60	393,105.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,424,770.00	5,571,750.00
210408	Бараа материал акталсны зардал	-	2,590,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	669,968.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	210,000.00	
210604	Урсгал засвар	459,968.00	
2107	Томилолт, зочны зардал	240,000.00	795,000.00
210702	Дотоод албан томилолт	240,000.00	795,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,809,500.00	13,899,868.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,520,000.00	459,968.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	9,075,000.00	11,880,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	214,500.00	559,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,632,220.10	19,888,555.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,025,200.00	6,274,550.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,607,020.10	13,614,005.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,786,896.37	10,102,473.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,949,621.00	2,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,949,621.00	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,837,275.37	8,102,473.19
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,837,275.37	8,102,473.19
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	59,347,747.27	(7,900,602.49)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	59,347,747.27	(7,900,602.49)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>276,605,400.00</u>	<u>240,905,200.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	5,000.00	-
120009	Бусад орлого	5,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	276,600,400.00	240,905,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	276,600,400.00	240,905,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	276,600,400.00	240,905,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>212,238,400.00</u>	<u>233,391,800.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	212,238,400.00	233,391,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	195,451,503.63	223,289,326.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	146,636,229.13	166,531,037.31
210101	Үндсэн цалин	114,158,529.13	132,724,137.31
210102	Нэмэгдэл	16,610,800.00	17,940,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,866,900.00	15,866,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,793,334.90	21,408,700.00
210201	Тэтгэврийн даатгал	17,793,334.90	21,408,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,946,421.60	6,189,331.50
210401	Бичиг хэрэг	958,000.00	813,700.00
210402	Тээвэр, шатахуун	1,413,700.00	4,344,476.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	380,651.60	433,005.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,194,070.00	598,150.00
2105	Нормативт зардал	2,435,000.00	2,430,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,435,000.00	2,430,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,786,400.00	5,663,090.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,238,800.00	1,729,600.00
210604	Урсгал засвар	2,547,600.00	3,933,490.00
2107	Томилолт, зочны зардал	1,190,000.00	1,199,000.00
210702	Дотоод албан томилолт	1,190,000.00	1,199,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,974,118.00	14,411,568.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,504,118.00	511,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	11,880,000.00	11,880,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	590,000.00	1,019,868.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	690,000.00	5,456,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	690,000.00	5,456,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,786,896.37	10,102,473.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,949,621.00	2,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,949,621.00	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,837,275.37	8,102,473.19
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,837,275.37	8,102,473.19

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>64,367,000.00</u>	<u>7,513,400.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	63,867,000.00	7,513,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	63,867,000.00	7,513,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	63,867,000.00	7,513,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	63,867,000.00	7,513,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(63,867,000.00)</u>	<u>(7,513,400.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	500,000.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	477,502.00	977,502.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	977,502.00	977,502.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	742,060,566.40	4,276,266.40	(208,099,240.46)	538,237,592.34
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	742,060,566.40	4,276,266.40	(208,099,240.46)	538,237,592.34
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	59,347,747.27	59,347,747.27
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	742,060,566.40	4,276,266.40	(148,751,493.19)	597,585,339.61
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	742,060,566.40	4,276,266.40	(148,751,493.19)	597,585,339.61
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(7,900,602.49)	(7,900,602.49)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	742,060,566.40	4,276,266.40	(156,652,095.68)	589,684,737.12

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	238,905,200.00	230,802,726.81	8,102,473.19	96.61
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	171,269,300.00	166,531,037.31	4,738,262.69	97.23
Үндсэн цалин	137,462,400.00	132,724,137.31	4,738,262.69	96.55
Нэмэгдэл	17,940,000.00	17,940,000.00	-	100.00
Унаа хоолны хөнгөлөлт	15,866,900.00	15,866,900.00	-	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,408,700.00	21,408,700.00	-	100.00
Тэтгэврийн даатгал	21,408,700.00	21,408,700.00	-	100.00
Хангамж, бараа материалын зардал	8,279,900.00	6,789,231.50	1,490,668.50	82.00
Бичиг хэрэг	1,030,000.00	1,013,700.00	16,300.00	98.42
Тээвэр, шатахуун	5,413,700.00	4,344,476.00	1,069,224.00	80.25
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	636,200.00	433,005.50	203,194.50	68.06
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200,000.00	998,050.00	201,950.00	83.17
Нормативт зардал	2,435,400.00	2,430,000.00	5,400.00	99.78
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,435,400.00	2,430,000.00	5,400.00	99.78
Эд хогшил, урсгал засварын зардал	11,170,900.00	11,114,590.00	56,310.00	99.50
Багаж, техник, хэрэгсэл	7,236,900.00	7,181,100.00	55,800.00	99.23
Урсгал засвар	3,934,000.00	3,933,490.00	510.00	99.99
Томилолт, зочны зардал	1,199,000.00	1,199,000.00	-	100.00
Дотоод албан томилолт	1,199,000.00	1,199,000.00	-	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,142,000.00	14,411,568.00	730,432.00	95.18
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	990,000.00	511,700.00	478,300.00	51.69
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
Даатгалын үйлчилгээ	11,880,000.00	11,880,000.00	-	100.00
Тээврийн хэрэгслийн татвар	182,000.00	-	182,000.00	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,090,000.00	1,019,868.00	70,132.00	93.57
Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	6,918,600.00	1,081,400.00	86.48
Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	6,918,600.00	1,081,400.00	86.48
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	240,905,200.00	240,905,200.00	-	100.00
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	240,905,200.00	240,905,200.00	-	100.00
Улсын төсвөөс санхүүжих	240,905,200.00	240,905,200.00	-	100.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	977,502.00	(977,502.00)	

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Монгол төрийн түүхийн музейн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2019			САГ-2020/18/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	МОНГОЛ ТӨРИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙН		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Ерөнхий журналаас шатахууны зардлыг тусгаарлан авч СТ, бараа материалын тодруулга тайлантай тохирч байсан боловч замын хуудсыг тулган шалгахад 2018 оны зарлагыг тайлант онд тайлагнан зарлагдсан байсан.	327.0	Зөвлөмж өгөх	Аж ахуйн нярав	Б.Сүрэнхорол
2	Оргил софт ХХК-н авлага 6197,4 мянган төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй. Шүүхээр шийдвэрлүүлэхээр хандсан боловч эх гэрээ байхгүй, сураггүй алга болсон шалтгаанаар шүүхээс буцсан байна.	6,197.40	Зөвлөмж өгөх	Музейн захирал	Н.Оюунтэгш
		6,524.4			

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing a conclusion.